



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/72

Сангийндалай

Рашаант багийн малын "А" дансны
баримтыг хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10, 23 дугаар зүйлийн 23.2.9, 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалт, аймгийн Архивын Улсын байцаагчийн 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр албан шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор 4-р багийн 2013-2018 оны мал тооллогын А дансны баримтыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Эрдэнэтуул (Нийгмийн даатгалын Улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Ж.Бадамцэцэг (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: М.Золжаргал (Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан)

С.Бадамгарав (Засаг даргын Тамгын газрын нярав)

И.Дүрзээ (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

2. "А" дансны баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 18-ны дотор хүлээн авч, Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-т танилцуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА

